

Төслийн мэдээллийн тайлангийн энэхүү орчуулсан хувь нь 2016оны 3-р сарын 29-ний байдлаарх англи эхэд суурилсан болно.



Монгол Улс: Зуд, ой хээрийн түймрийн эсрэг чадавхийг орон нутагт бэхжүүлэх төсөл (өмнөх нэршил: Гамшгийн эрсдэлийг удирдах, зохицуулах чадавхийг бэхжүүлэх төсөл)

Төслийн нэр	Зуд, ой хээрийн түймэртэй тэмцэх чадавхийг орон нутагт бэхжүүлэх төсөл (төслийн өмнөх нэр: Гамшгийн эрсдэлийг удирдах, зохицуулах чадавхийг бэхжүүлэх төсөл)	
Төслийн дугаар	48236-001	
Төсөл хэрэгжих улс	Монгол Улс	
Төслийн статус	Санал болгосон	
Төслийн төрөл / Дэмжлэгийн хэлбэр	Буцалтгүй тусламж	
Санхүүжилтийн эх үүсвэр /Мөнгөн дүн	Буцалтгүй тусламж: Зуд, ой хээрийн түймэртэй тэмцэх чадавхийг орон нутагт бэхжүүлэх төсөл (төслийн өмнөх нэр: Гамшгийн эрсдэлийг удирдах, зохицуулах чадавхийг бэхжүүлэх төсөл)	
	Тодорхойлогдоно	3 сая ам.дол.
Холбогдох стратегийн зорилт	Байгаль орчны тогтвортой хөгжил Эдийн засгийн хүртээмжтэй өсөлт	
Хөгжил өөрчлөлтийг чиглүүлэгч салбарууд	Засаглал ба чадавхи бэхжүүлэлт (ЗЧБ) Мэдлэгийн шийдлүүд (МХ) Түншлэл (ТҮН)	
Салбар /Дэд салбар	Хөдөө аж ахуй ба байгалийн нөөц баялаг – Хөдөө аж ахуй, байгалийн баялаг, хөдөөгийн хөгжил	
Жендерийн тэгш эрх ба жендерийн үзэл баримтлалыг төлөвлөлт,	Жендерийн тэгш байдлын үзэл баримтлалыг үр өгөөжтэй нэвтрүүлсэн	

Төслийн товч агуулга

Санал болгож буй энэхүү төслийг Онцгой байдлын ерөнхий газрын хүсэлтэд тулгуурлан эрсдэлийн удирдлагын тогтолцоог Монгол Улсад бэхжүүлэх тал дээр ажилладаг бусад байгууллагуудтай зөвлөлдөх замаар боловсруулсан болно. Уг төсөл нь эрсдэлийн удирдлагыг бэхжүүлэх зорилгоор одоо хэрэгжиж буй ажлыг дэмжихийн зэрэгцээ холбогдох байгуулагуудын зүгээс эрсдэлийн удирдлагын чиглэлээр урьд өмнө хэрэгжүүлсэн ажлаас олж авсан сургамжууд дээр тулгуурлах болно. Эрсдэлийн удирдлага менежментэд зайнаас тандан судлах арга технологийг ашиглах асуудлаар Японы сансар судлалын албатай хамтран ажиллах боломжийг төслийн хүрээнд судална.

Энэхүү төсөл нь бүгдэд хүртээмжтэй бөгөөд байгаль орчны тогтвортой хөгжлийг дэмжихэд чиглэгдсэн, АХБ-ны 2014-2016 онуудад Монгол Улстай хамтран хэрэгжүүлэх түншлэлийн стратегийн үзэл баримтлалтай бүрэн нийцсэн. Дээрхи стратегийн бичиг баримтад ган, зуд, шар усны үер зэрэг нийгэм эдийн засагт үлэмж хохирол (ялангуяа малчдын хувьд) учруулдаг байгаль цаг уурын үзэгдлүүдийн тохиолдох давтамж хоёр дахин өссөн тухай дурдсан байдаг. Мал аж ахуйн салбарын хувьд бэлчээрийн доройтлын асуудал нэн тэргүүнд тулгамдаж буй асуудал бөгөөд агаарын хэмийн хэт уналт нь салбарын үр шим, малын тоо толгойн ихээхэн хорогдлыг дагуулж байна. Тогтвортой хөгжлийн замыг сонгосон тус улсын хувьд малчдынхаа амьжиргааг дэмжин хамгаалахын тулд байгалийн баялгийн удирдлагын оновчтой тогтолцоог нэврүүлэх, байгалийн гамшгийг сөрөг нөлөөллөөс хамгаалах үр дүнтэй арга хэмжээг болосруулах нь туйлын чухал байгааг мөн онцолсон. Энэхүү төсөл нь (i) Гамшгаас хамгаалаах тухай хууль; (ii) Галын аюулгүй байдлын тухай хууль; (iii) Ой хээрийн түймрээс хамгаалах тухай хуулийн дагуу гамшгийн эрсдэлийн чиглэлээр хүлээсэн чиг үүрэг, хариуцлагаа үр дүнтэй хэрэгжүүлэхэд нь ОБЕГ-т дэмжлэг үзүүлэх зорилготой. Төсөл нь УИХ-аас 2011 онд соёрхон батласан Монгол Улсын “Гамшгаас урьдчилан сэргийлэх үндэсний садавхийг бэхжүүлэх нь” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжих зорилготой. Санал болгож буй уг төсөл нь АХБ-ны 2014-2020 онуудад хэрэгжүүлэх Гамшгийн эрсдэлийн цогц удирдлагын хэрэгжилтийг хангах дор дурдсан зорилго бүхий үйл ажиллагааны төлөвлөгөөнд тэргүүлэх ач холбогдолтой гэж заагдсан 2 асуудалтай мөн шууд хамааралтай. Үүнд: (i) АХБ-ны бүхий л үйл ажиллагаанд Гамшгийн эрсдэлийн цогц удирдлагын зарчмыг баримтлах, (ii) АХБ-ны гшүүн хөгжиж буй улс орнуудын гамшгийн эрсдэлийн цогц удирдлагыг хэрэгжүүлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшгийн эрсдэл тохиолдсон нөхцөлд цаг алдалгүй түргэн шүүрхай, эдийн засгийн үр ашигтай байдлаар хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэх чадавхи, мэдлэг мэдээлэл, хүч нөөцийг бэхжүүлэх. Энэхүү төсөл нь АХБ-ны 2015 оны зээлийн бус хөтөлбөрүүдийн жагсаалтад тусгагдаад байна.

Энэхүү төсөл нь гамшгийн эрсдэлийн удирдлагын чиглэлээр Монгол Улсын Засгийн газрын сүүлийн жилүүдэд олсон ололт амжилтыг бататгах бөгөөд гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшгийн бэлэн байдлыг дээшлүүлэх, хор уршгийг арилгах үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэх Засгийн газрын чадамжийг улам бэхжүүлэхэд чиглэгдэнэ.

Төслийн үндэслэл ба Орон\Бүсийн стратегитай уялдсан байдал

Монгол Улс нь хүн ам маш бага нягтаршилтай улс орон хэдий ч байгалийн төрөл бүрийн гамшигт өртөмтгйд тооцогдох улс билээ. Удаан үргэлжлэх хүйтэн өвлийн улирал, жилийн туршид маш бага хэмжээтэй унах хүр тунадас, зуны ган гачиг гээд байгаль цаг уурын нөхцөл байдлыг хүндрүүлэх маш олон хүчин зүйлс байна. Дэд бүтцийн хөгжил сул, улам бүр нэмэгдэх хандлагатай байгаа ядуурлын төвшин, институцын тогтолцоо хүчин чадлын хувьд хязгаарлагдмал, малчин өрхүүд нүүдлийн байдлаар мал аж ахуй эрхэлдэг зэрэг хүчин зүйлс нь байгалийн болон хүний хүчин зүйлээс үүдэлтэйгээр амь нас, амьжиргаагаа алдах эрсдэлийг хот хөдөө аль алинд улам бүр нэмэгдүүлж байна.

Сүүлийн 10 жилд давтамж нь улам ихсэж байгаа ган зуд хөдөөгийн хүн амын үлэмж хэсэгт сөргөөр нөлөөлж хохирол учруулаад байна. Хот суурин газруудын хүн ам улам бүр өсөж байгаатай холбоотой тэдний гал, үер, газар хөдлөлтөнд өртөх эрсдэл улам нэмэгдэж байна. 1994 оноос хойш хугацааны 12 жилд нь зудын үзэгдэл тохиолдолдсон бөгөөд 2009-2010 оны зудаар Монгол Улсын нийт малын тоо толгойн 25 хувь хорогдсон билээ. Үүний үр дагавраар 97,000 малчин өрхийн амьжиргаа шууд байдлаар хүндэрсэн байдаг. Мөн түүнчлэн, ой хээрийн түймрийн уршгаар малчид төдийгүй Монгол орны экосистемд сөргөөр нөлөөлж, тун саяхан хувийн тоноглол хэрэгсэл тааруутай байсан гал сөнөөгдийн амь эрсэдсэн. Урьд өмнө байгаль экологийн ердийн үзэгдэл мэтээр тохиолдож байсан бол одоо гал түймрийн олонхи нь хүний буруутай үйл ажиллагаанаас үүдэн гарч байгаа тул аюулт үзэгдлийн тоонд тооцогдохоор болоод байна. Эрчимтэй хөгжиж буй уул уурхайн салбар ч байгалийн экосистемд эрсдэл учруулаад зогсохгүй иргэдийн аюулгүй байдалд мөн тодорхой эрсдэлүүдийг учруулж байна. Дээрхи асуудал бэрхшээлүүд нь байгаль цаг уурын дулаарлын нөлөөгөөр улам хурцдаж, цаашид тохиох байгалийн аюулт үзэгдлүүд илүү ширүүн, хохирол ихтэй болох, тус улсын эмзэг экосистемийг чанарын хувьд улам бүр доройтуулах, улмаар хөдөөгийн ядуу өрхүүдийн амьжиргааг улам хүнд болгох аюултай байна. Онцгой байдлын ерөнхий газар нь Иргэний хамгааллын алба, Улсын нөөцийн алба болон Гал түймэртэй тэмцэх улсын алба зэрэг гурван байгууллагын суурин дээр 2004 онд байгуулагдсан. 2011 оны 3-р сард Монгол Улсын Их Хурлаас “Гамшгаас сэргийлэх үндэсний хөтөлбөр” болон “Гамшгийн эрсдэлээс хамгаалах үндэсний чадавхийг бэхжүүлэх нь” үндэсний хөтөлбөрийг соёрхон батласан. Гэвч гамшгийн эрсдэлийн удирдлага зохицуулалтын хүрээнд ОБЕГ

байгууллага/салбар хоорондын уялдаа холбоо, зохицуулалтыг хангах тал дээр тодорхой бэрхшээл сорилтуудтай тулгарсаар байгаа бөгөөд байууллагуудын энэ чиглэлээр хүлээх үүрэг хариуцлагыг тодорхой болгох асуудал хамгийн тулгамдсан, нэн тэргүүнд шийдвэрлэх ёстой асуудал байсан хэвээр байна.

Аймаг, сумын удирдлагууд гамшгийн эрсдэлийн удирдлагын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулсан байдаг бөгөөд тэдгээрт зориулсан сургалт семинарыг ОБЕГ-аас үе үе зохион байгуулдаг. Гэсэн хэдий ч орон нутаг дахь гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшгийн бэлэн байдлыг дээшлүүлэх, гамшгийн хор уршгийг эдийн засгийн үр ашигтай байдлаар арилгах чадавхи нутгийн удирдлага, ард иргэд зэрэг аль аль төвшинд туйлын дутмаг байсаар байна.

Төслийн үр нөлөө

1. Эрсдэл, эмзэг байдлыг бууруулж, гамшгийн удирдлагын тогтолцоог бэхжүүлснээр үндэсний аюулгүй байдал сайжирна (Монгол Улсын Гамшгаас Сэргийлэх Үндэсний Бодлого 2011).

2. АХБ-ны гишүүн хөгжиж буй орнуудын гамшгаас хамгаалах, сэргээн босгох чадавхи бэхжинэ (АХБ-ны Гамшгийн эрсдэлийн цогц удирдлагын хэрэгжилтийг хангах, 2014-2020 онуудад хэрэгжүүлэх Үйл ажиллагааны төлөвлөгөө).

Төслийн үр дагавар

Гамшгийн эрсдэлийн удирдлагыг хариуцах үндэсний болон орон нутгийн эрх бүхий байгууллагуудын болон малчдын зуд, ой хээрийн түймэртэй тэмцэх чадвар, чадавхи бэхжинэ

Төслийн үр дүн

1. Орон нутагт суурилсан Гамшгийн эрсдэлийн удирдлагын төлөвлөгөөг боловсруулна
3. Улс, аймаг, сумын төвшинд гамшгийн эрсдэлийг удирдах, хор уршгийг арилгах удирдлагын чадавхи бэхжинэ
2. Гамшгийн бэлэн байдлыг сайжруулах жижиг хэмжээний дэд бүтцийн төслийг түршилтын журмаар хэрэгжүүлнэ
Төслийн удирдлагын үйл ажиллагаа

Газар зүйн байршил

Байгаль орчин нийгмийн хамгааллын ангилал

Байгаль орчны асуудал	С
Албадан нүүлгэн шилжүүлэлт	С
Уугуул иргэд	С

Байгаль орчин нийгмийн хамгааллын товчоон

Байгаль орчны асуудал

Албадан нүүлгэн шилжүүлэлт

Уугуул иргэд

Оролцогч талуудын харилцаа, оролцоо ба зөвшилцөл

Төслийн төлөвлөлтийн үед

Төслийн хэрэгжилтийн үед

Бизнесийн боломж

Зөвлөх үйлчилгээ АХБ-ны хөрөнгөөр санхүүжих бүх зөвлөх үйлчилгээг АХБ-ны Зөвлөх үйлчилгээг авахад мөрдөх журмын дагуу авч ажиллана (2013 онд анх батлагдаж түүнээс хойш үе үе шинэчлэгдэн батлагдаж байгаа журам).

Худалдан авалт АХБ-ны санхүүжилтээр хийгдэж байгаа бүх худалдан авалтыг АХБ-ны худалдан авалтад мөрдөх журмын дагуу хэрэгжүүлнэ (2015 онд анх батлагдаж түүнээс хойш үе үе шинэчлэгдэн батлагдаж байгаа журам). Төслийн удирдлагын нэгж болон хэрэгжүүлэгч байгууллагуудын нэрийн өмнөөс худалдан авах ажиллагааг хэрэгжүүлэх талыг сонгон ажиллуулна.

Хариуцагч талууд

АХБ-ны хариуцсан ажилтан	Шабано Тирмизи
АХБ-ны хариуцсан газар	Зүүн Азийн газар
АХБ-ны хариуцсан хэлтэс	Байгаль орчин, байгалийн баялаг, хөдөө аж ахуйн хэлтэс, Зүүн Азийн Газар
Хэрэгжүүлэгч байгууллага	Онцгой байдлын ерөнхий газар Партизаны гудамж, Улаанбаатар хот

Цагалбар

Концепцийг батлах	2015 оны 11-р сарын 26
Урьдчилсан судалгаа	2016 оны 4-р сарын 25-аас 2016 оны 5-р сарын 5
Удирдлага хянан хэлэлцэх хурал	2016 оны 6-р сарын 30
Төслийг батлах	2016 ны 11-р сарын 29
Сүүлд хийсэн хяналт	-
Сүүлд хийсэн нэмэлт	2015 оны 12-р сарын 17

Төслийн Мэдээллийн Тайлан (ТМТ)–д төсөл болон хөтөлбөрийн талаарх хураангуй мэдээлэл багтдаг: ТМТ нь одоогоор хэрэгжиж байгаа ажлын тухай байдаг тул тайлангийн анхны хувилбарт зарим мэдээлэл багтаагүй байж болох ба бэлэн болсон үед нь нэмж оруулдаг. Санал болгож байгаа төслийн талаарх мэдээлэл нь урьдчилсан бөгөөд тойм шинж чанартай.

АХБ нь энэхүү Төслийн Мэдээллийн Тайлан (ТМТ)–г хэрэглэгчдэд гагцхүү мэдээллийн чанартай хүргэж байгаа бөгөөд ямарваа нэгэн амлалт, баталгаа өгөхгүй. АХБ нь өндөр чанарын мэдээллийн контент гаргахыг эрмэлзсэн хэдий ч тухайн мэдээллийг “байгаагаар нь” ойлговол зохих бөгөөд арилжааны шаардлагыг хангах, тодорхой зорилгоор ашиглахад нийцэх эсвэл бусдын эрхэд халдахгүй байх гэх мэт ямарваа нэгэн шууд болон шууд бус баталгааг өгөхгүй. Нэн ялангуяа, тайланд агуулагдсан мэдээлэл үнэн зөв бөгөөд бүрэн бүтэн болох талаар ямар нэгэн баталгаа эсвэл мэдэгдэл гаргаагүй болно.